



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 81/ч

Шивээговь сум

“Суманд цэвэрлэх байгууламж байгуулах
зураг төсөв боловсруулах” ажлыг
хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Суманд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсөв боловсруулах” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа (Засаг даргын орлогч дарга)

Нарийн бичгийн дарга:

Э.Халиун (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ш.Чинболд (Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын захирал)

Д.Дэлгэрдалай (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Бямбасүрэн (БЗӨБЦТС-ТӨХК-ийн Говьсүмбэр салбарын Хэсгийн ахлагч, засварын мастер)

Ц.Даваасүрэн (Эрүүл мэндийн төвийн

2 дугаар багийн эмч)

Ц.Адъяа (1 дүгээр багийн иргэн)

2. “Суманд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсөв боловсруулах”
ажлыг ажлын даалгаварт заасан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга
(Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ

